

Хүчирхэгжих ухаан: Бусдыг ойлгож мэдсэнээр өөрийгөө идэвхижүүлэх шинэлэг арга

1. Хүчирхэгжилт гэж юу вэ?

Хүчирхэгжилт гэдэг нь хүмүүст итгэл найдвар, хүсэл мөрөөдөл, урам зориг өгөхийн зэрэгцээ тэдэнд амьдрах эрч хүчийг бий болгож байдаг үзэгдэл бөгөөд энэ нь хүн бүрт байдаг гайхалтай чанар юм.

Хүн бүр төрөлхийн гайхамшигт авьяас чадвартай бөгөөд тэд амьдралынхаа туршид тухайн чадваруудаа хөгжүүлсээр байдаг.

Хүчирхэгжилт гэдэг нь булагаас тасралтгүй ундрэн гарах рашаан лугаа адил өөрт байгаа тэрхүү гайхамшигт хүчин чадлаа ориглуулан гаргах үзэгдэл юм. Өөрөөр хэлбэл хүчирхэгжих үйл явцыг өөрийн дотор буй нуугдмал боломжуудаа ил болгох гэж ойлгож болно.

Нийгмийн халамж болон эрүүл мэндийн үйлчилгээний салбарт тухайн хүнд буй гайхамшигт чадамжууд нь нийгмийн хөгжил, хувь хүний сайн сайхан байдлын төлөө хийж буй үйл ажиллагаагаар өдөөгдөн хөглөгдөж байдаг байна.

Бизнес болон аж үйлдвэрлэлийн салбарын хувьд ажилчин албан хаагчдын боломжит хүчин чадлыг байгууллагын хөгжил болон ажилчдын мэргэжлийн ур чадвартай уялдуулсанаар тэдний чадваруудыг нэмэгдүүлж улмаар эрч хүчээр дүүрэн ажиллах боломжийг нээж өгдөг.

Хүчирхэгжих үйл явц нь дараах найман зарчимд тулгуурладаг:

1. Өөрийн гэсэн зорилготой байх
2. Санаачлага болон шийдвэр гаргах чадвартай байх
3. Өөрт тулгарсан асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх, болон эргэцүүлэн бодох чадвартай байх
4. Амжилт, болон алдаанаасаа суралцаж, дүн шинжилгээ хийж, өөрийгөө хөгжүүлэх чадвартай байх
5. Дотоод хүчин чадлаа нээн илрүүлж улмаар эерэг зан үйлээ бататгах чадвартай байх
6. Асуудал шийдвэрлэхэд оролцох эрмэлзэлтэй байж, үүрэг хариуцлагаа ухамсарлах
7. Аливаа асуудлыг шийдвэрлэх болон нөөц бололцоогоо ашиглах үйл явцыг дэмжин ажиллах
8. Тухайн хүний нөхцөл байдлыг сайжруулах хүсэл тэмүүлэлтэй байх (тухайлбал өөрийн зорилго эсвэл сайн сайхан байдалд хүрэх гэх мэт)

2. Хүчирхэгжилтийн нэгдмэл загвар

Хүчирхэгжих үйл явц нь дараах гурван түвшингээс бүрдэнэ: Хувь хүний хүчирхэгжилт, хамт олны хүчирхэгжилт, олон нийт байгууллагын хүчирхэгжилт.

Дээрх гурван өөр төрлийн хүчирхэгжилтийн хэлбэрийг нэгтгэж буй гол хүчин зүйлс нь үр дүн болон тогтвортой байдал бөгөөд эдгээр шинж тэмдгийг нэгтгэн хүчирхэгжилтийн нэгдмэл загвар гэж нэрлэж болох юм.



Зураг 2-1 Хүчирхэгжилтийн нэгдмэл загвар (Анмэ, 2012)

3. Хүчирхэгжих нөхцлийг бүрдүүлэгч үнэт зүйлс

Хүчирхэгжих нөхцлийг бүрдүүлэхийн тулд хүчирхэгжилтийн найман үнэт зүйлсийг мэдэж байх хэрэгтэй. Энэхүү элементүүд нь хүчирхэгжих явцыг дэмжихээс гадна үр дүнг үнэлэх гал шалгуур болж өгдөг.

(1) Бусдыг ойлгох

Бусдыг ойлгох гэдэг нь хувь хүн өөрийн гэсэн хүсэл тэмүүлэлээ мэдэж байхаас гадна бусдын хүслийг ч мөн адил ойлгодог байх гэсэн үг юм.

(2) Өөрийгөө идэвхижүүлэх

Өөрийгөө идэвхижүүлэх гэдэг нь багийн гишүүн бүр өөрийн хийж буй үйл ажиллагаагаараа дамжуулан өөрийн үнэт зүйлсийг олж мэдэх үйлдэл юм.

(3) Салбар дундын шинж чанар

Салбар дундын шинж чанар нь багийн гишүүн бүр харилцан хамааралтай асуудлаар бие биенийхээ хийж буй үйл ажиллагаанд оролцож байгаагаар тодорхойлогдоно.

(4) Оролцоо

Оролцоо нь багийн гишүүн бүр өөрийн хийж буй үйл ажиллагаанаасаа үр шим хүртэж буйг хэмжих шалгуур болдог.

(5) Тэгш байдал

Хэрэв тухайн төсөл хөтөлбөр нь шударга бус явагдаж байвал гишүүд үйл ажиллагаанд нь оролцохгүй байх боломжтой бөгөөд багийн гишүүн бүрт санал зөвлөмж өгч ажиллах хэрэгтэй.

(6) Ялгаатай байдлыг олж мэдэх

Ялгаатай байдал нь хувь хүн, хамт олон төдийгүй хүрээлэн буй орчны хувьд давуу тал болдог

(7) Уян хатан чанар

Уян хатан чанар нь хувь хүн эсвэл байгууллагын хөгжилд эерэгээр нөлөөлөхийн тулд хийж буй өөрчлөлтүүд үр дүнтэй эсэхийг хэмжих шалгуур болдог.

(8) Шинэлэг санаачилга

Ирээдүйн хөгжил дэвшлийн төлөө хийгдэж буй шинэлэг санаачилга болон тогтвортой байдал нь амар тайван, аюулгүй орчинг бий болгодог.

4. Хүчирхэгжих загвар

Дараагийн дэвшилтэт үед шилжих явцдаа одоогийн нөхцөл байдлаа үнэлэж дүгнэх нь чухал бөгөөд энэ тохиолдолд Case (Creation-Бүтээх, Adaptions-Дасан зохицох, Sustenance-Тогтворжих, Expansion-Хүрээгээ тэлэх) загварыг (Анмэ & МакКолл 2008) олон улс оронд хэрэглэж байна. Энэхүү хүчирхэгжих загвар нь олон төрлийн аргуудыг ашиглан одоогийн хөгжлийн түвшингээ олж мэдсэнээр өөрийгөө хүчирхэгжүүлэхээр ажиллаж буй хүн бүрт нэн хэрэгтэй юм.



Зураг 4-1 Хүчирхэгжих үйл явц хөгжих үе шат (Анмэ & МакКолл, 2008)

5. Хүчирхэгжих үйл ажиллагааны загвар

Хүчирхэгжих үйл ажиллагаа нь тухайн төсөл хөтөлбөрийн хэрэгцээ болон хүчин чадлыг хэмжих шалгууруудыг бий болгосноор улам үр дүнтэй байх болно (Зураг 4-2). Тус загварын онцлог шинж нь тухайн төслийн зорилго болон үйл ажиллагааг дэмжиж буй аргачлалууд нь төслийг амжилтанд хүргэж буй эсэхийг тодорхойлж, улмаар үйл ажиллагааны чиглэл, дараалал болон үндэслэлийг нарийн тусгаж өгсөн байдаг оршино. Мөн түүнчлэн тухайн төсөл хөтөлбөр нь амжилттай хэрэгжиж буй эсэхээс үл хамааран хүчирхэгжих арга зам (хэрхэн) болон үндэслэлийг (яагаад) логик дэс дараалал буюу уялдаа холбоотойгоор тус загварт тодруулж өгсөн байна (Анмэ & МакКолл 2008).

Дээрх загвар нь дараах зургаан үе шаттайгаар загварлагдсан болно:

1-р шат: Хүсэн хүлээж байсан үр дүн юу байсан вэ?

2-р шат: Одоогийн нөхцөл байдал ямар байна вэ?

3-р шат: Урьдчилсан нөхцөл байдал буюу үндэслэл юу байсан вэ?

4-р шат: Тухайн асуудалд үр дүнтэйгээр нөлөөлөх анхан шатны нөхцлүүд, асуудал болон үндэслэл юу вэ?

5-р шат: Ямар арга хэмжээ (стратеги), үйл ажиллагаанууд үр дүнг бий болгоход нөлөөлөх вэ?

6-р шат: Ямар үр дүнд хүрч болох вэ?



Зураг 4-2 Хүчирхэгжих үйл явцыг дэмжих загвар (Анмэ, 2005)

6. Хүчирхэгжих үйл явцыг бүрдүүлэх долоон зөвлөмж:

- (1) Тодорхой зорилготой байх
- (2) Таатай харилцаа, хамтын ажиллагааг бий болгох
- (3) Бусдыг ойлгох, ойлголцол дээр тулгуурласан нөхцлийг бий болгох
- (4) Ая тухтай, тайван орчинг бүрдүүлэх
- (5) Оролцооны уян хатан хэлбэрийг бий болгох
- (6) Үргэлж хөгжих, дэвших зорилготой байх
- (7) Бодит үнэлэлт, дүгнэлт өгөх